



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/46

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 385 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/662 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (COVID-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, “Цагаан сар нэгдсэн арга хэмжээ”-г хэрэгжүүлж ажиллах зорилгоор аймгийн Онцгой комиссын шуурхай штабт хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмж, шатахууны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Онцгой комиссын шуурхай штабын зардалд зарцуулах 11,324,700 (арван нэгэн сая гурван зуун хорин дөрвөн мянга долоон зуу) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0097

Аймгийн Засаг даргын 2022 оны  
..01..дүгээр сарын ..31..-ны өдрийн  
..1/46..дугаар захирамжийн  
хавсралт



### Зардлын тооцоо

д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шуурхай штабт хэрэглэгдэх дэлгэц /Samsung 55 инч/	ш	1	3,000,000	3,000,000
2	Зурагтны хөл	ш	1	480,000	480,000
3	Цагаан сар нэгдсэн арга хэмжээнд хэрэглэгдэх шатахуун /2022.01.10-2022.02.20/	л	1230	2890	3,554,700
4	Зөөврийн компьютер	ком	1	2,300,000	2,300,000
5	Улсын Онцгой комиссын нэгдсэн журмаар тавьсан шуурхай штабын суурин телефон утасны 2021 оны 11, 12 дугаар сарын төлбөр Callpro үйлчилгээний төлбөр	ш	2	220,000	440,000
6	Онцгой комиссын гишүүдэд талархал, өргөмжлөл	ш	21	50,000	1,050,000
7	Бичгийн цаас	боодол	5	20,000	100,000
8	Шуурхай штабтаас цахим хурал хийхэд хөлтэй камер, спикер /чанга яригч/	ком	1	400,000	400,000
Нийт дүн					11,324,700.00